



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 85

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.4, 6.6 дахь заалт, 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын Үндэсний номын сангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй нийт 26,500,000.00 (хорин зургаан сая таван зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 2 (хоёр) ширхэг автомашиныг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хуулийн хэлтсийн дарга Л.Цэдэвсүрэн, Монголын Үндэсний номын сангийн захирал Б.Ичинхорлоо нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Акталж, данснаас хасаж сэлбэгээр худалдсан автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолт, дээрх арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

0000140


 Төрийн ёмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020
 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн
 085 дугаар тогтолцын хавсралт
Монголтын Үндэсний номын сангийн Үндсэн хөрөнгөд
бүртгэлтэй, актлаж дансаас хасах автомашини жагсаалт

Д/Д	Автомашины марк, улсын нийтийн дугаар, зориулалт, арлын дугаар	Ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын анхны үнэ (төгрөгөөр)	Хурумтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өргөтгөх (төгрөгөөр)
1	MMC Делика 9776 УБТ, арап РО4W-0004579	1995/2008	133093	12,000,000.00	12,000,000.00	-
2	Ниссан Экстрайл 2732 УНМ арап NT30011682	2002/2011	211890	14,500,000.00	14,500,000.00	1,812,500.00
	Нийт дүн			26,500,000.00 (хорин зургаан сая таван зуун мянга)	(нэг сая найман зуун хоёр мянга таван зуу)	